МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИЙН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУШААЛ

2025 оны 06 сарын 06 өдөр Дугаар А/90 Улаанбаатар хот

Журам батлах тухай

Шинжлэх Ухааны Академийн Эрхзүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2, 7.4.1 дэх хэсэг, Барааны тэмдэг, газарзүйн заалтын тухай хуулийн 12, 13, 17 дугаар зүйл, Шинжлэх Ухааны Академийн дүрмийн 22 дугаар зүйлийн "в" дэх хэсэг, ШУА-ийн технологи дамжуулах журмын 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн барааны тэмдгийг ашиглах тухай журмыг 1 дүгээр хавсралтаар, ШУА-ийн эзэмшдэг барааны тэмдгийг ашиглах төлбөрийн хэмжээг 2 дугаар хавсралтаар, барааны тэмдэг ашиглах хүсэлт гаргах маягтыг 3, 4 дүгээр хавсралтаар, гэрээний загварыг 5 дугаар хавсралтаар тус тус батлалсугай.

2. Энэхүү журмыг батлагдсан өдрөөс эхлэн мөрдөж, хэрэгжүүлж ажиллахыг Тэргүүлэгчдийн газрын Инновац технологи, цахим бодлогын хэлтсийн дарга /Д.Батхуяг/-д, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тэргүүлэгчдийн газрын дарга /А.Баярбаатар/-д тус тус үүрэг болгосугай.

ЕРӨНХИЙЛӨГЧ С.ДЭМБЭРЭЛ

23251003

ШУА-ийн Ерөнхийлөгчийн 2025 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 41/90 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИЙН
БАРААНЫ ТЭМДГИЙГ АШИГЛАХ ТУХАЙ ЖУРАМ

Нэгдүгээр зүйл. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь Оюуны өмчийн тухай хууль, Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хууль, ШУА-ийн технологи дамжуулах журмын дагуу ШУА нь дангаараа эсхүл хамтран эзэмшигчээр эзэмшдэг барааны тэмдгийг ашиглах, ашиглуулах эрхийн хамгаалалт хийх талаарх харилцааг зохицуулахад оршино.

1.2. Монгол Улсын Шинжлэх Ухааны Академи болон түүний харьяа хүрээлэн, төв, нэгж байгууллагууд (цаашид "ШУА" гэх) өөрийн үйл ажиллагааг бусад байгууллага, хуулийн этгээдээс ялгах зорилгоор бэлгэдэл, барааны тэмдэг ашиглана.

1.3. ШУА-ийн бэлгэдэл, барааны тэмдгийн стандартыг ШУА-ийн брэндбүүк болон Монгол Улсын холбогдох стандартад нийцүүлэн дагаж мөрдөнө.

1.4. Энэхүү журмаар зохицуулагдахгүй асуудлыг ШУА-ийн "Технологи дамжуулах журам"-аар зохицуулна.

Хоёрдугаар зүйл. Нэр томьёоны тодорхойлолт

2. Энэхүү журамд нэр томьёог дараах утгаар ойлгоно.

2.1. "Барааны тэмдэг" гэж Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуулийн 3.1.1 дэх хэсэгт заасны дагуу "иргэн, хуулийн этгээд өөрийн бараа, үйлчилгээг бусад этгээдийн бараа, үйлчилгээнээс ялгах зорилгоор хэрэглэх ялгагдах чадвартай илэрхийллийг";

2.2. "Бүртгэгдсэн барааны тэмдэг гэж Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуульд заасны дагуу улсын бүртгэлд бүртгүүлсэн барааны тэмдгийг;

2.3. "ШУА-ийн харьяа нэгж" гэж ШУА-ийн Тэргүүлэгчдийн газар, харьяа хүрээлэн, ахисан түвшний их сургууль, судалгааны төв, лаборатори, газар, хэлтсийг;

2.4. "Технологи дамжуулах төв" гэж ШУА-ийн Тэргүүлэгчдийн газрын Инновац технологи, цахим бодлогын хэлтсийг (цаашид "ИТЦБХ" гэх);

2.5. "ШУА-ийн барааны тэмдэг" гэж ШУА-ийн ашиглаж байгаа болон ашиглахаар төлөвлөсөн барааны тэмдгийг;

2.6. "ШУА-ийн харьяа нэгжийн хариуцсан барааны тэмдэг" гэж ШУА-ийн харьяа хүрээлэн, ахисан түвшний их сургууль, судалгааны төв, лаборатори, газар, хэлтэс нь өөрсдийн бараа, үйлчилгээнд ашиглах барааны тэмдгийг хэлнэ.

2.7. "Гэрээлэгч" гэж ШУА-ийн барааны тэмдгийг ашиглах зөвшөөрөл авч, лицензийн гэрээ байгуулсан этгээдийг хэлнэ.

Гуравдугаар зүйл. Барааны тэмдэг ашиглах тухай

3.1. ШУА нь өөрийн бараа, үйлчилгээг бусад этгээдийн бараа, үйлчилгээнээс ялгах зорилгоор барааны тэмдэг ашиглаж болно.

3.2. ШУА нь ашиглаж байсан, ашиглаж байгаа эсхүл цаашид ашиглахаар төлөвлөж буй барааны тэмдгийг эрхийн хамгаалалт хийлгэхийн тулд дотоод, гадаадын эрх бүхий байгууллагад бүртгүүлж болно.

3.3. ШУА-ийн судлаач, ажилтан нь судалгааны үр дүнг илэрхийлэх барааны тэмдэг ашиглаж болно. Энэ нь бусад барааны тэмдгээс ялгагдах байдалтай байна. Үүнийг тухайн судлаач, ажилтны харьяалах ШУА-ийн харьяа нэгж ИТЦБХ-тэй зөвшилцөж шийдвэрлэнэ.

Дөрөвдүгээр зүйл. Хэрэглэх байдал, хэлбэр

4.1. ШУА-ийн барааны тэмдгийг тусгайлан зөвшөөрснөөс бусад тохиолдолд ашгийн бус зорилгоор ашиглана.

4.2. ШУА-ийн барааны тэмдгийг ШУА-ийн харьяаны бус этгээдэд ашиглуулах тохиолдолд төлбөртэй ашиглуулах бодлого барина.

4.3. ШУА-ийн стратеги, бодлогод нийцүүлэн барааны тэмдгийг ашиглах зорилго, хэлбэр, хүрээг барааны тэмдэг тус бүрээр нь тухайн барааны тэмдгийг хариуцсан нэгж гаргаж болно.

Тавдугаар зүйл. Барааны тэмдэгт зохицуулалт хийх нэгж

5.1. ШУА-ийн барааны тэмдэгтэй холбоотой үйл ажиллагааг хариуцаж ажиллах, зохицуулалт хийх нэгж нь ИТЦБХ байна.

5.2. ИТЦБХ дараах эрх, үүргийг хүлээнэ. Үүнд:

5.2.1. Барааны тэмдгийн эрхийн хамгаалалт хийх, хүчинтэй хугацааны сунгалт хийх;

5.2.2. Барааны тэмдгийг зөв зохистой ашиглахтай холбоотой үйл ажиллагаанд энэ журмын 11 дүгээр зүйлд заасны дагуу хяналт тавих;

5.2.3. ШУА-ийн нэр дээр бүртгэгдсэн Барааны тэмдгийг ашиглах зөвшөөрөл олгох эсэх;

5.2.4. Барааны тэмдгийг ашиглуулах лицензийн гэрээг байгуулах;

5.2.5. ШУА-ийн нэр дээр бүртгэгдсэн Барааны тэмдгийг бусдад ашиглуулах гэрээний хэрэгжилтэд хяналт тавих;

5.2.6. Барааны тэмдэгтэй холбоотой гарсан маргаан, зөрчлийг шийдэхэд ШУА-ийг төлөөлөх;

5.2.7. Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч, хуульчтай харьцах;

Зургаадугаар зүйл. Барааны тэмдэг ашиглах тухай хүсэлт гаргах

6.1. ШУА-ийн харьяа нэгж нь барааны тэмдэг ашиглах хүсэлтээ ШУА-ийн Тэргүүлэгчдийн газарт бичгээр мэдэгдэнэ.

6.2. ШУА-ийн харьяа нэгж нь өөрийн бараа, үйлчилгээнд ашиглах барааны тэмдгийг зөвхөн ШУА-ийн нэр дээр бүртгүүлнэ.

6.3. Энэ журмын зүйл, заалтыг зөвшөөрсөн тохиолдолд хувь хүн, хуулийн этгээд нь ШУА-ийн Барааны тэмдэг ашиглах хүсэлтийг гаргаж болно. Хүсэлт хүлээн авснаас хойш 1 сарын дотор шийдвэрлэж хариу өгнө.

Долоодугаар зүйл. Барааны тэмдгийг бүртгүүлэх

7.1. ИТЦБХ нь ШУА-ийн барааны тэмдгийг эрх бүхий байгууллагад бүртгүүлэх, бүртгүүлсэн барааны тэмдгийн эрхийг сунгуулах, шилжүүлэх, барааны тэмдэгт өөрчлөлт оруулах зэрэг холбогдох үйл ажиллагааг хариуцан ажиллана.

7.2. Барааны тэмдгийг бүртгүүлэх, сунгуулах, шилжүүлэх, болон өөрчлөлт оруулахтай холбогдон гарах зардлыг тухайн барааны тэмдгийг ашиглах нэгж, этгээд гаргана.

7.3. ШУА-ийн харьяа нэгж нь ашигладаг барааны тэмдгээ сунгуулах шаардлагагүй гэж үзсэн тохиолдолд, энэ тухайгаа бичгээр ШУА-ийн Тэргүүлэгчдийн газарт мэдэгдэнэ.

Наймдугаар зүйл. Бүртгүүлсэн барааны тэмдгийг нийтэд мэдээлэх

8.1. ИТЦБХ нь эрхийн хамгаалалт хийгдсэн барааны тэмдгийг нийтэд болон холбогдох этгээдэд мэдээлнэ.

Есдүгээр зүйл. Барааны тэмдэг ашиглах тухай зөвшөөрөл олгох

9.1. ШУА-ийн барааны тэмдгийг ашиглахыг хүссэн этгээдийн зохих заавар, маягтын дагуу гаргасан хүсэлтийг ШУА-ийн Тэргүүлэгчдин газар хүлээн авч, зөвшөөрөл олгох эсэх тухай анхан шатны дүгнэлт гаргана (Хавсралт 3 ба 4).

9.2. ШУА-ийн стратеги төлөвлөгөө, Технологи дамжуулах журам ба энэхүү журмыг үндэслэн ШУА-ийн барааны тэмдгийг ашиглах зөвшөөрлийг хүсэлт гаргагчид өгөх эсэхийг ИТЦБХ-ийн гаргасан дүгнэлтийг үндэслэн ШУА-ийн Байгалийн ухааны салбарын дэд ерөнхийлөгч шийдэх бөгөөд татгалзсан тохиолдолд шалтгаанаа хүсэлт гаргагчид тайлбарлан мэдэгдэх үүрэгтэй.

9.3. ШУА нь хүсэлтийг хүлээн авсан тохиолдолд лицензийн гэрээ байгуулах бөгөөд аль болох онцгой эрхтэй лиценз олгож, гэрээлэгчийг хамгаалах бодлого баримтална.

9.4. ШУА-ийн барааны тэмдэг ашиглах тухай гэрээ байгуулж, төлбөр тооцоогоо хийснээр ШУА-ийн барааны тэмдгийг ашиглах эрх үүснэ.

Аравдугаар зүйл. Барааны тэмдэг ашигласны төлбөр

10.1. ШУА-ийн барааны тэмдгийг ашиглах этгээд нь тухайн барааны тэмдгийг ашиглуулахтай холбоотой байгуулсан гэрээний дагуу төлбөрийг төлнө. Төлбөрийн хэмжээг ШУА-ийн Ерөнхийлөгч батална.

10.2. ШУА-ийн барааны тэмдгийг ашиглах төлбөрийн хэмжээг ашиглах хэлбэр, хүрээнээс хамааран хавсралт 2-д заасны дагуу тогтооно.

10.3. ШУА-ийн барааны тэмдгийг дараах нөхцөлд ашиглавал төлбөр төлөхгүй. Үүнд:

10.3.1. ШУА-ийн албан бичиг, баримт, хэвлэмэл хуудас;

10.3.2. ШУА-ийн судлаач, ажилтан, суралцагч, гэрээт судлаач нэрийн хуудас;

10.3.3. ШУА-ийн албан ёсны вэб хуудас, сэтгүүл, цахим суваг болон түүнтэй адилтгах зүйл;

10.3.4. ШУА-аас эрхлэн гаргаж байгаа албан ёсны танилцуулга;

10.3.5. Харьяа нэгжээс албан ёсоор эрхлэн гаргаж байгаа сурах бичиг, ном, эрдэм шинжилгээний сэтгүүлд ашиглах;

10.4. Харьяа нэгжийн хариуцсан барааны тэмдгийг ашиглах төлбөрийн хэмжээг тухайн нэгж барааны тэмдэг бүрээр гаргаж болно. Ингэж гаргаагүй бол хавсралт 1-д заасан төлбөрийн дагуу тооцно.

10.5. Барааны тэмдэг ашиглуулснаас орох орлогыг дараах байдлаар хуваарилна. Үүнд:

10.5.1. "ШУА-ийн барааны тэмдэг"-ийг ашиглуулснаас орсон орлогын 60%-ийг ШУА-ийн Тэргүүлэгчдийн газрын үйл ажиллагаанд, 40%-ийг инновацын асуудал хариуцсан нэгжийн үйл ажиллагаанд зарцуулна.

10.6. "ШУА-ийн харьяа нэгжийн хариуцсан барааны тэмдэг"-ийг ашиглуулснаас орсон орлогын 50%-ийг тухайн нэгжид, 50%-ийг ШУА-ийн Тэргүүлэгчдийн газрын инновацын асуудал хариуцсан нэгжийн үйл ажиллагаанд хуваарилана.

Арван нэгдүгээр зүйл. Барааны тэмдгийн ашиглалтад тавих хяналт

11.1. ШУА, харьяа нэгж нь барааны тэмдэг ашиглахдаа холбогдох хууль, дүрэм, журмыг чандлан мөрдөж ажиллана.

11.2. ШУА, харьяа нэгж нь хариуцаж байгаа барааны тэмдгийн дотоод ашиглалтад хяналт тавьж ажиллах үүрэг хүлээнэ. Лицензийн гэрээгээр ашиглуулж байгаа барааны тэмдгийн ашиглалтад ИТЦБХ хяналт тавьж ажиллана.

11.3. ИТЦБХ нь ШУА, харьяа нэгжид барааны тэмдгийн ашиглалтад холбогдох зөвлөмж болон бусад мэргэжлийн туслалцаа, зөвлөгөөгөөр ханган ажиллана.

11.4. ШУА-ийн барааны тэмдгийн талаар хувь хүн эсхүл хуулийн этгээдээс ирсэн мэдээллийг ИТЦБХ хүлээн авч, зохих арга хэмжээ авна.

11.5. Барааны тэмдгийн ашиглалтад зохицуулалтад ШУА-ийн Байгалийн ухааны салбарын дэд ерөнхийлөгч хяналт тавьж ажиллана.

Арван хоёрдугаар зүйл. Гомдол, маргаан, зөрчил шийдэх

12.1. ИТЦБХ нь ШУА-ийн барааны тэмдэгтэй холбогдох гомдол, маргаан, зөрчилд ШУА-ийг төлөөлөн ажиллана. Холбогдох зардлыг тухайн барааны тэмдгийг ашиглах нэгж/этгээд гаргана.

12.2. ШУА-ийн барааны тэмдгийн эзэмших, ашиглах эрхийг зөрчиж, хууль бусаар ашигласнаас үүсэх зөрчил, хохирлыг хууль, хяналтын байгууллагын тогтоосон буруутай этгээд арилгах үүрэг хүлээх бөгөөд холбогдох зардлыг төлж хохиролгүй болгоно.

12.3. Барааны тэмдгийг ашиглах, ашиглуулахтай холбогдон гарах аливаа маргаантай асуудлыг оролцогч талууд харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэх ба тодорхой шийдэлд хүрч чадахгүй тохиолдолд хууль, хяналтын газарт хандаж шийдвэрлүүлнэ.

Арван гуравдугаар зүйл. Бусад

13.1. ШУА-ийн барааны тэмдгийг ашиглах төлбөрийн хэмжээг заасан Хавсралт 2-ыг ИТЦБХ-ийн саналыг үндэслэн ШУА-ийн Ерөнхийлөгчийн тушаалаар шинэчлэн баталгаажуулна.

13.2. ШУА-ийн Барааны тэмдгийг холбогдох хууль, журам, байгуулсан гэрээг зөрчиж буруу ашигласан бол гэрээлэгчид өгсөн зөвшөөрлийг хүчингүй болгох, эсвэл ашиглаж байгаа үйл ажиллагааг зогсоож болно. Энэ тохиолдолд өмнө төлсөн төлбөрийг буцаахгүй.

13.3. Зохих журмын дагуу ШУА-ийн Барааны тэмдгийг ашиглах зөвшөөрөл авснаас бусад этгээд ШУА-ийн барааны тэмдгийг ашиглавал, уг үйл ажиллагааг зогсоож, хохирлыг нэхэмжлэхэд дэмжлэг үзүүлнэ.

13.4. ШУА-ийн барааны тэмдэг эзэмшигчийн эрхийг зөрчсөнөөс ШУА-д эд хөрөнгийн хохирол учруулсан тохиолдолд хохирлыг нэхэмжилнэ.

13.5. ШУА-ийн Барааны тэмдгийг холбогдох хууль, журмыг зөрчин ашигласан, хэрэглэсэн, буруугаар ашигласан, эсхүл зөвшөөрөлгүй ашигласан үйл ажиллагаанаас үүдэн гарсан аливаа хохирлыг ШУА хариуцахгүй.

13.6. Энэхүү журамд нэмэлт өөрчлөлт оруулах эсэхийг ИТЦБХ-ийн саналыг үндэслэн ШУА-ийн удирдлагууд хэлэлцэж шийдвэрлэнэ.

--- ooo O ooo ---

ШУА-ийн Ерөнхийлөгчийн 2025 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн А/198 дугаар тушаалын 2 дугаар хавсралт

ШУА-ийн барааны тэмдгийг ашиглах төлбөрийн хэмжээ

№	ШУА-ийн барааны тэмдэг ашиглах зориулалт	Бүтээгдэхүүний үнийн хувиар төлөх		Нэг удаагийн багц төлбөр (төгрөгөөр)
		Төлбөрийн хэмжээ (төгрөгөөр)	Босго төлбөр (төгрөгөөр)	
1	**Хүсэлт гаргах**			
1.1	ШУА-ийн барааны тэмдгийг ашиглах тухай Гэрээ байгуулах хүсэлт гаргах	Хүсэлт бүрд 300 000*1		
1.2	ШУА-ийн барааны тэмдгийг ашиглах Гэрээг сунгуулах хүсэлт гаргах	Хүсэлт бүрд 300 000*1		
2	**Ашгийн бус зориулалтаар***2,*3			
2.1	Бараа, үйлчилгээнд ашиглах	Борлуулах бол борлуулалтын үнэ эсхүл борлуулахгүй бол нэрлэсэн зардлын 10%.	500 000	5 000 000
2.2	Хэвлэмэл материалд ашиглах	Борлуулах бол борлуулалтын үнэ эсхүл борлуулахгүй бол нэрлэсэн зардлын 5%.	250 000	2 500 000
2.3	Зар сурталчилгаанд ашиглах	Холбогдох этгээд/газраас зөвшөөрөл авна.		
2.4	Хурал, семинарт ашиглах	Холбогдох этгээд/газраас зөвшөөрөл авна.		
2.5	ШУА албан ёсоор зохион байгуулах, эсхүл, албан ёсоор оролцох хөтөлбөр, төслийн хүрээнд ашиглах	Холбогдох этгээд/газраас зөвшөөрөл авна.		
2.6	ШУА-ийн харьяа ашгийн бус сайн дурын нэгдэл (дугуйлан, секц, холбоо, хоршоо, эвлэл) үйл ажиллагаандаа ашиглах	Холбогдох этгээд/газраас зөвшөөрөл авна.		
3	**Ашгийн зориулалтаар***2			
3.1	Бараа, үйлчилгээнд ашиглах	Борлуулалтын үнийн 10%.	750 000	5 500 000
3.2	Хэвлэмэл материалд ашиглах	Борлуулалтын үнийн 5%.	250 000	2 500 000
3.3	Зар сурталчилгаанд ашиглах	Холбогдох этгээд/газраас зөвшөөрөл авна.		
3.4	Хурал, семинарт ашиглах	Холбогдох этгээд/газраас зөвшөөрөл авна.		

Анхааруулга:

*1: Гаргасан хүсэлт нь зөвшөөрөгдсөн эсэхээс хамаарахгүй бөгөөд эргэн төлөгдөхгүй, буцаахгүй, бусад төлбөртэй зөрүү тооцохгүй.

*2: Төлсөн босго төлбөрийг буцаан олгохгүй. Төлбөрийн хэмжээ нь босго төлбөрт хүрэхгүй тохиолдолд зөрүүг олгохгүй. Гэрээ сунгахад өмнөх зөрүүг бодохгүй.

*3: Ашгийн бус зориулалтаар ашиглаж болох этгээд: ТББ, төрийн байгууллага, ашгийн бус боловсролын байгууллага.

ШУА-ийн Ерөнхийлөгчийн 2025 оны
06 дугаар сарын 06-ны өдрийн 17 дугаар
тушаалын 3 дугаар хавсралт

ШУА-ийн Тэргүүлэгчдийн газрын
Инновац, технологи, цахим бодлогын хэлтэст
Барааны тэмдэг ашиглах тухай хүсэлт гаргах нь

Дараах барааны тэмдгийг ашиглах хүсэлтэй байгаа тул хүсэлт гаргав.
Хүсэлт гаргасан _____ нь "ШУА-ийн барааны тэмдгийг ашиглах тухай журам"-ыг уншиж танилцан, журмын заалт бүрийг зөвшөөрч байна.

Хүсэлт гаргасан:

Овог, нэр	
Харьяалагдах байгууллага	
Ашиглах барааны тэмдэг	
Ашиглах зорилго	
Ашиглах хугацаа	
Гарын үсэг	/ /
Огноо	
Төлбөр төлсөн баримт хавсаргасан эсэх	**Тийм.** **Үгүй**.

Зөвшөөрөл

Дээрх хүсэлтийн дагуу ШУА-ийн барааны тэмдэг ашиглахыг
зөвшөөрөв.
үл зөвшөөрөв.

Барааны тэмдгийг ашиглах байгууллага/хувь хүн	
Хариуцагч этгээд	
Ашиглах барааны тэмдэг	
Ашиглах зорилго	**ашгийн бус зорилгоор** **ашгийн зорилгоор**
Ашиглах хугацаа	
Гэрээ	
Зөвшөөрөл олгосон этгээд	
Гарын үсэг	
Огноо	

ШУА-ийн Ерөнхийлөгчийн 2025 оны
06. дугаар сарын 06-ны өдрийн А/ 98 дугаар
тушаалын 4 дүгээр хавсралт

(Маягт – Бусад этгээд)

ШУА-ийн Тэргүүлэгчдийн газрын Инновац, технологи, цахим бодлогын хэлтэст
Барааны тэмдэг ашиглах тухай хүсэлт гаргах нь

Дараах барааны тэмдгийг ашиглах хүсэлтэй байгаа тул хүсэлт гаргав.
Хүсэлт гаргасан _____ нь "ШУА-ийн барааны тэмдгийг ашиглах тухай журам"-ыг уншиж танилцан, журмын заалт бүрийг зөвшөөрч байна.

Хүсэлт гаргасан:

Овог, нэр	
Харьяалагдах байгууллага	
Ашиглах барааны тэмдэг	
Ашиглах зорилго	
Ашиглах хугацаа	
Гарын үсэг	/ /
Огноо	
Төлбөр төлсөн баримт хавсаргасан эсэх	**Тийм.** **Үгүй.**
Гэрээний санал байгаа эсэх	**Тийм.** **Үгүй.**

Зөвшөөрөл

Дээрх хүсэлтийн дагуу ШУА-ийн барааны тэмдэг ашиглахыг
зөвшөөрөв.
үл зөвшөөрөв.

Барааны тэмдгийг ашиглах байгууллага/хувь хүн	
Хариуцагч этгээд	
Ашиглах барааны тэмдэг	
Ашиглах зорилго	**ашгийн бус зорилгоор** **ашгийн зорилгоор**
Ашиглах хугацаа	
Гэрээ	
Зөвшөөрөл олгосон этгээд	
Гарын үсэг	
Огноо	

ШУА-ийн Ерөнхийлөгчийн 2025 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн А/190 дугаар тушаалын 5 дугаар хавсралт

БАТЛАВ.
ДЭД ЕРӨНХИЙЛӨГЧ

.....

Барааны тэмдэг ашиглуулах гэрээний загвар

ШУА эрхийг нь эзэмшдэг барааны тэмдгийг ашиглуулах гэрээг (цаашид "Гэрээ" гэх) нэг талаас Монгол Улсын Шинжлэх Ухааны Академи (цаашид "ШУА" гэх), нөгөө талаас ..... (цаашид "Ашиглагч" гэх) нар ШУА-ийн Барааны тэмдгийг ашиглах тухай журмын дагуу дараах нөхцөлийг харилцан тохирч байгуулав.

Нэг. Ерөнхий зүйл

1.1. ШУА нь ..... барааны тэмдгийн (цаашид "Барааны тэмдэг" гэх) оюуны өмчийн бүх эрх буюу эдийн засгийн бүх эрхийг эзэмшигч мөн.

1.2. Энэхүү гэрээнд ШУА нь барааны тэмдгийг Ашиглагчид дараах нөхцөлтэй Барааны тэмдэг ашиглах лицензийн эрх олгоно.

1.2.1. Онцгой эрхтэй/эрхгүй

1.2.2. Цааш дамжуулах эрхтэй/эрхгүй

1.2.3. Цуцлах боломжтой

1.3. Энэхүү гэрээ нь ШУА-ийг бусад этгээдтэй лицензийн гэрээ байгуулахыг хориглох нөхцөл болохгүй.

1.4. Ашиглагч нь ШУА-ийн Барааны тэмдгийг ашигласны төлбөрт ..... төгрөгийг дараах хуваарийн дагуу .... хугацаанд төлнө.

1.4.1. .....

1.4.2. .....

Хоёр. Барааны тэмдэг ашиглах

2.1. ШУА нь ШУА-ийн Барааны тэмдгийн цорын ганц хууль ёсны эзэмшигч нь мөн бөгөөд эдийн засгийн бүх эрхийг эзэмшигч гэдгийг Ашиглагч тал хүлээн зөвшөөрч байна. Ашиглагч нь энэхүү гэрээний 2-д зааснаас бусад хэлбэрээр ямар нэг эрх эдлэхгүй.

2.2. Ашиглагч нь Барааны тэмдгийг зөвхөн ШУА-ийн зөвшөөрөл олгосон нөхцөл, хэлбэрийн дагуу гэрээний хүчинтэй хугацааны туршид ашиглах бөгөөд ШУА-ийн нэр хүндэд хохирол учруулахгүй байвал зохино. Ашиглагч нь ШУА-ийн Барааны тэмдгийн жинхэнэ эрх эзэмшигч гэж өөрийгөө зарлах, эсвэл эрх эзэмшигч нь гэж төөрөгдөлд оруулах үйлдвэл хийхийг хатуу хориглоно.

2.3. Ашиглагч нь Барааны тэмдгийг ашиглахдаа энэхүү гэрээний нөхцөлийг дагаж мөрдөхөөс гадна, ШУА-ийн Барааны тэмдгийг ашиглах тухай журмын зүйл заалтыг хатуу сахиж ажиллана.

Гурав. Ашиглах болон цуцлах нөхцөл

3.1. Энэхүү гэрээний нөхцөл нь гэрээ байгуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр байж, Ашиглагч нь гэрээний нөхцөлийг зөрчөөгүй тохиолдолд ..... хүртэл үйлчилнэ.

3.2. Гэрээний хүчин төгөлдөр хугацаа дууссан, Ашиглагч нь гэрээ зөрчсөн тохиолдолд ШУА нь гэрээг нэн даруй цуцлах эрхтэй.

Дөрөв. Эрх, үүрэг

4.1. ШУА нь лиценз олгогчийн хувьд ..... үүрэгтэй

4.2. Талууд нэг нэгнийхээ өмнөөс гуравдагч этгээдэд учруулсан эдийн болон эдийн бус баялгийн аливаа хариуцлага хүлээхгүй.

4.3. Ашиглагч нь ШУА-ийн Барааны тэмдгийг чанарын шаардлага хангасан бараа бүтээгдэхүүн/үйлчилгээнд ашиглаж, ШУА-ийн нэр хүндэд хохирол учруулахгүй үйл ажиллагаа явуулна.

4.4. ШУА нь лицензийн гэрээний хугацаанд Барааны тэмдгийн төлбөр, хураамжийг төлж, хүчинтэй байх нөхцөлийг бүрдүүлэх үүрэгтэй.

4.5. Ашиглагч нь энэхүү гэрээгээр ашиглаж байгаа Барааны тэмдгийг нь гуравдагч этгээд зөрчиж байгаа, эсвэл зөрчих гэж байгаа тохиолдолд ШУА-д мэдэгдэх үүрэгтэй. ШУА нь зөрчлийг арилгуулах арга хэмжээг Ашиглагчтай хамтарч хууль хяналтын газарт мэдэгдэж арилгуулна.

Тав. Бусад

5.1. Энэхүү гэрээний нөхцөл, заалт бүр нь нууц мэдээлэл бөгөөд байгууллагын болон хувь хүний нууцын тухай хуулиар хамгаалагдана. Хууль хяналтын байгууллагын ямар нэг хүсэлтээр энэ гэрээний тухай мэдээллийг задруулах тохиолд талууд нэг нэгэндээ энэ тухай бичгээр мэдэгдэх үүрэгтэй.

5.2. Энэхүү гэрээтэй холбогдон гарах аливаа маргааныг талууд аль болох зөвшилцөх байдлаар шийдэхийг эрмэлзэх бөгөөд хэрэв ямар нэг шийдэлд хүрч чадахгүй бол хууль хяналтын байгууллагад хандаж шийдвэрлүүлнэ.

5.3. Гэрээнд ямар нэг нэмэлт өөрчлөлт оруулах хүсэлтэй бол энэ тухайгаа заавал бичгээр мэдэгдэнэ.

5.4. Ашиглагч нь цаашид үйл ажиллагаа явуулах боломжгүй болж, Барааны тэмдэг ашиглах боломжгүй болсон, төлбөр төлөх чадваргүй болсон тохиолдолд нэн даруй ШУА-д энэ тухайгаа бичгээр мэдэгдэж гэрээг цуцална.

Лиценз олгогч ШУА-ийг төлөөлж	Барааны тэмдэг ашиглагч
Инновац, технологи, цахим бодлогын хэлтэс	
.....	.....